

Үндэсний геологийн албаны
2022 оны 01 дүгээр сарын 10 өдрийн
1/09 тоот албан бичгийн хавсралт

**ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021 ОНЫ ТАЙЛАН**

№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулах ажил	Хэрэгжилт
1	Ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр	Ажилтан ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай компьютер, техник хэрэгслийн судалгаа хийж, удирдлагад танилцуулах, зайлшгүй шаардлагатай техник хэрэгслийг захиалж, ажилтныг хэвийн ажиллах нөхцлөөр хангах /Компьютер, сканнер, камер, сейф, ажлын хувцас, багаж төхөөрөмж г.м/	Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор нийт 867.0 сая.төг зарцуулсан. Энэхүү зардал нь 2021 оны төсөвт тусгагдаагүй. УУХҮЯ-наас нэмэлт зохицуулалт хийсэн. Үүнд: Геологийн ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж – 97.8 сая.төг Урсгал засвар – 69.0 сая.төг Ажлын хувцас – 4.5 сая.төг Хүнд хортой нөхцөлийн сүүний зардал -1.6 сая.төг Түлээ нүүрсний хөнгөлөлт – 600 мян.төг Шинээр төрсөн 4 хүүхэд – 1.2 сая.төг Эрүүл мэндийн шалтгаантай 1-2 сарын цалинтай чөлөө Ковидын урьдчилсан тест – 700 мян.төг Ковидын дараах дархлаажуулалт – 4.0 сая.төг Үр дүнгийн урамшуулал – 82.0 сая.төг
2	Тусламж дэмжлэгийн чиглэлээр	Ажилтанд тусламж дэмжлэг шаардлагатай болсон тухай бүрд журмын дагуу шийдвэр гаргах, дэмжлэг тусламж үзүүлэх	2021 оны 02 дугаар сарын 10-ны Б/04 дугаар тушаалаар нийт 32 албан хаагчийн ээлжийн амралтын хуваарийг батлаж, хуваарийн дагуу амралтыг биеээр эдлүүлсэн. Албан хаагчдаас цалинтай, цалингүй чөлөө хүссэн -5, ажлаас чөлөөлөгдөх -3, ажилд орох -4, нийгмийн баталгааны дэмжлэг хүссэн 2 /түлээ нүүрсний хөнгөлөлт-3 хүн, шинэ хүүхэдтэй болсон-4 хүн / нийт 14 өргөдөл хүлээн авч холбогдох хууль журмын дагуу шийдвэрлүүлсэн.
3	Тусламж дэмжлэгийн чиглэлээр	Өндөр насны тэтгэвэрт гарах ажилтан албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн дагуу нэг удаагийн тэтгэмж олгох	2021 оны 1-р улиралд багтан 2022 онд тэтгэвэрт гарах 3 албан хаагчид Төрийн албаны оны тухай хуулийн дагуу нэг удаагийн тэтгэмж олгох 82.1 сая төгрөгийг байгууллагын 2022 оны төсөвт төлөвлөж, батлуулсан. Үүний 67.0 сая төгрөг нь Геологийн баримтын төв архиваас тэтгэвэрт гарах 2 албан хаагчийн зардал болно. Мөн архивын нэмэгдэл гэх ангилалын 2 албан хаагчийн дэмжлэгийн зардлыг 2022 оны төсөвт суулган УУХҮЯ-нд хүргүүлсэн боловч ЗГ 2021 оны 46 дугаар тогтоол /Ковидын үеийн хэмнэлтийн тухай/-ын дагуу төсвийн төлөвлөгөөнөө хасуулсан болно.

№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулах ажил	Хэрэгжилт
4	Албан хаагчдын сургалт хөгжлийн чиглэлээр	"УГА-ны ажиллагсдын 2021 оны сургалтын төлөвлөгөө"-г Агентлагийн даргаар батлуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургалтад жигд хамруулах	2021 оны сургалтын төлөвлөгөөг нэгжүүдийн хэрэгцээ шаардлага саналыг үндэслэн боловсруулж, агентлагийн даргаар батлуулсан. Ковидын нөхцөл байдлаас хамааран төлөвлөгөөт сургалтууд цахимаар голчлон зохион байгуулагдсан. Нийт 26 сургалтад нийт 34 албан хаагчийг бүрэн хамруулсан. /давхардсан тоогоор 323 хүн/ Сургалтын дэлгэрэнгүй мэдээлэл бүртгэлийг хавсаргав.
5	Албан хаагчдын сургалт хөгжлийн чиглэлээр	Төрийн болон өөрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд ажилтны ажил үүргийг зохицуулах, чөлөө олгох, цалин хөлсийг олгох асуудлыг шийдэх, дэмжих	Төрийн албаны сургуулийн мэргэшүүлэх сургалтууд ковидын нөхцөл байдлаас хамааран цахимаар зохион байгуулагдсан бөгөөд 6 удирдах албан тушаалтан, төрийн захиргааны 10 гүйцэтгэх албан тушаалтан хамрагдаж албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан тусгай шаардлага шалгуурыг хангасан. 2.Төрийн үйлчилгээний 1 ажилтан магистрийн түвшний сургалтад, 2 төрийн захиргааны албан тушаалтан мэргэшсэн геологичийн сургалтад хамрагдаж, ажлын цагийн уян хатан нөхцөлөөр хангаж байна.
6	Албан хаагчдын сургалт хөгжлийн чиглэлээр	Шинээр ажилд орж буй ажилтан, албан хаагчид агентлагийн хөдөлмөрийн дотоод журам, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулах	2021 оны 3 дугаар улирлын байдлаар 2 төрийн үйлчилгээний албан хаагч, 2 гэрээт ажилтан шинээр томилогдсон. Байгууллагын дотоод журам болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмтэй танилцах зааварчилгаа өгч ажилласан. Байгууллагын дотоод журамыг дотоод сүлжээнд, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг байгууллагын цахим хуудсанд тус тус байршуулж, нийт албан хаагчид танилцах нээлттэй боломжийг бүрдүүлсэн.
7	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрөөх чиглэлээр	Албан хаагчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах	2021 оны төсвийн төлөвлөгөөнд албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зардлыг тусгасан боловч Ковидийн тухай хууль болон ЗГ-ийн 2020 оны 41 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэх зорилгоор УУХҮЯ-наас хасаж баталсан тул энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон.
9		Нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	
10		Хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулах	

№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулах ажил	Хэрэгжилт
11	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрөөх чиглэлээр	Хүндээр өвчилсөн болон хүнд өвчний улмаас гадаад улсруу өндөр төлбөртэй эмчилгээ, сувилгаанд явах шаардлагатай албан хаагчдад хандив, туслалцаа үзүүлэх	2021 оны төсвийн төлөвлөгөөнд уг зардлыг төлөвлөсөн боловч Ковидийн тухай хууль болон ЗГ-ийн 2020 оны 41 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэх шалтгаанаар хасагдсан тул энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон. Эрүүл мэндийн шалтгаантай албан хаагчид 2 сар хүртэл хугацаатай цалинтай чөлөө олгосон. /ГСХ-Т.Мөнхсоёл/

Тайлбар: Төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн тухай хуульд албан хаагчдын ниймгийн баталгааг хангах асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлэхээр заагдсан хэдий ч байгууллагын 2021 оны төсөвт уг төрлийн зардал огт тусгагдаагүй тул дээрх арга хэмжээг байгууллагын дотоод нөөц бололцоо, УУХҮЯ-нд уламжлан нэмэлт зохицуулалтаар зохих түвшинд хэрэгжүүлсэн.

ТАНИЛЦСАН: ДАРГА

ХЯНАСАН: ТЗУХ-ИЙН ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТЗУХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

О.ЧУЛУУН

С.ШИНЭ-ОД

Х.МӨНГӨНЖИГҮҮР